



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/42

Бор-Өндөр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.4.1 дэх заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 16 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын “Хүйх 5-р баг”-ийн нутаг дэвсгэрт байгалийн нөхөн сэргээлт хийх зорилгоор 2,5 га газарт бэлчээрийн ургамлыг хамгаалах, доройтсон бэлчээрийн газарт нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх “Эрдэнэс Талст Хүдэр” ХХК-д ажил гүйцэтгэх урьдчилгаа 70 хувийн санхүүжилт болох 10 000 000 (арван сая) төгрөгийг олгосугай.

2. Тус ажлын хүрээнд зарцуулагдах 10 000 000 (арван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Болортуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ